



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар A/42

Улаанбаатар хот

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 9 дүүрэгт Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон он дамжин хийгдэж байгаа тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангулж мөрдүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж ажиллахад шаардлагатай шатахууны зардлын тооцог нэгдүгээр, ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардагдах шатахууныг худалдан авахад зарцуулах 809,732 (Найман зуун есөн мянга долоон зуун гучин хоёр) төгрөгийг тээвэр, шатахууны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Тохижилт, бүтээн байгуулалтын ажилд зөвлөн туслах үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн дарга (О.Оджаргал)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

